



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
О.ХОНГОРЗУЛ ТАНАА**

2025.02.25

№

ОАА-2025/1224/НА-ОАА-ТШЗ

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Аймгийн хөрөнгө оруулалтаар 65,481.8 мянган төгрөгийн өртөгтэй хийгдсэн дээврийн засварын ажлыг Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 525 дугаар албан бичгээр үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсний дагуу санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 4 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

432502253

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.3 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА





2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	198,297,807.84	213,285,412.79
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	112,860,098.64	110,504,455.99
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	112,860,098.64	110,504,455.99
3121	Төгрөг	112,860,098.64	110,504,455.99
31211	Төрийн сангийн харилцах	112,860,098.64	110,504,455.99
35	БАРАА МАТЕРИАЛ	85,437,709.20	102,780,956.80
354	Хангамжийн материал	85,437,709.20	102,780,956.80
35410	Бичиг хэргийн материал	-	82,500.00
35420	Аж ахуйн материал	83,184,959.20	89,269,842.80
35450	Барилгын засварын материал	-	9,260,200.00
35460	Хүнсний материал	-	1,495,664.00
35470	Бусад хангамжийн материал	2,252,750.00	2,672,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	592,388,804.92	618,240,544.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	592,388,804.92	618,240,544.88
392	Биет хөрөнгө	487,934,680.07	513,864,544.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	505,398,311.50	570,880,150.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(97,191,982.80)	(119,148,911.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,887,674.68	78,186,694.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(58,939,059.81)	(64,406,091.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,137,258.56	43,104,858.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,921,515.35)	(27,742,598.53)
39209	Зам, гүүрийн байгууламж	9,158,650.20	9,158,650.20
39210	Хуримтлагдсан элэгдэл	(3,522,558.00)	(4,227,069.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,084,117.39	38,084,117.39
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,585,196.60)	(14,454,235.92)
39217	Ном	4,428,980.30	4,428,980.30
393	Биет бус хөрөнгө	104,454,124.85	104,376,000.00
39301	Програм хангамж	2,171,100.00	2,171,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,092,975.15)	(2,171,100.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	104,376,000.00	104,376,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	790,686,612.76	831,525,957.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,428,192.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,428,192.00
413	Өглөг	-	2,428,192.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,428,192.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	790,686,612.76	829,097,765.67
51	Засгийн газрын хувь оролцоо	790,686,612.76	829,097,765.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	459,504,935.78	459,504,935.78

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51101	Өмч: - төрийн	459,504,935.78	459,504,935.78
512	Хуримтлагдсан үр дүн	(64,481,095.67)	(26,069,942.76)
51210	Өмнөх үеийн үр дүн	(64,481,095.67)	(64,481,095.67)
51220	Тайлант үеийн үр дүн	-	38,411,152.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	395,662,772.65	395,662,772.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	790,686,612.76	831,525,957.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,408,767,668.71	1,682,030,239.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,646,870.00	65,571,839.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,646,870.00	65,571,839.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,646,870.00	90,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	90,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,646,870.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		65,481,839.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,395,120,798.71	1,616,458,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,157,886,100.00	1,353,049,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,157,886,100.00	1,353,049,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	237,234,698.71	263,408,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	237,234,698.71	263,408,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,318,848,844.81	1,643,619,086.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,318,848,844.81	1,643,619,086.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,318,848,844.81	1,643,619,086.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	800,024,275.07	1,060,536,371.82
210101	Үндсэн цалин	800,024,275.07	717,425,501.27
210102	Нэмэгдэл	-	307,662,298.95
210104	Урамшуулал	-	35,448,571.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,143,964.60	130,568,749.80
210201	Тэтгэврийн даатгал	68,567,498.08	89,920,904.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,959,092.91	10,551,934.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,349,615.17	5,484,635.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,569,650.76	4,891,343.01
210205	Эрүүл мэндийн даатгал	15,698,107.68	19,719,932.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,536,214.71	245,887,592.00
210301	Гэрэл, цахилгаан	5,208,633.71	6,999,900.00
210302	Түлш, халаалт	183,051,107.00	219,708,900.00
210303	Цэвэр, бохир ус	12,276,474.00	19,178,792.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,930,708.54	3,850,330.40

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210408	Бараа материал акталсны зардал	1,930,708.54	3,850,330.40
2105	Нормативт зардал	121,941,445.00	128,776,856.00
210502	Хоол, хүнс	121,941,445.00	128,776,856.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,361,000.00	7,671,800.00
210604	Урсгал засвар	12,361,000.00	7,671,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,567,090.00	1,186,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,567,090.00	1,186,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,344,146.89	65,140,986.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,985,932.26	22,663,157.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,688,492.50	2,847,730.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,669,722.13	39,630,099.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	89,918,823.90	38,411,152.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	89,918,823.90	38,411,152.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,395,120,798.71	1,616,548,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	90,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	90,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	90,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	90,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,395,120,798.71	1,616,458,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,157,886,100.00	1,353,049,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,157,886,100.00	1,353,049,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	237,234,698.71	263,408,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	237,234,698.71	263,408,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,289,525,398.14	1,618,904,042.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,289,525,398.14	1,618,904,042.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,289,525,398.14	1,618,904,042.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	800,024,275.07	1,060,466,515.66
210101	Үндсэн цалин	571,630,368.39	717,355,645.11
210102	Нэмэгдэл	196,642,016.63	307,662,298.95
210104	Урамшуулал	31,751,890.05	35,448,571.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,143,964.60	130,638,605.96
210201	Тэтгэврийн даатгал	68,567,498.08	89,840,007.21
210202	Тэтгэмжийн даатгал	7,959,092.91	10,462,622.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,349,615.17	5,291,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,569,650.76	5,087,034.56

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210205	Эрүүл мэндийн даатгал	15,698,107.68	19,957,442.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,544,498.71	244,408,800.00
210301	Гэрэл, цахилгаан	5,208,633.71	6,999,900.00
210302	Түлш, халаалт	207,059,391.00	219,708,900.00
210303	Цэвэр, бохир ус	12,276,474.00	17,700,000.00
2105	Нормативт зардал	121,336,245.00	129,323,120.00
210502	Хоол, хүнс	121,336,245.00	129,323,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,690,200.00	19,000,000.00
210604	Урсгал засвар	12,690,200.00	19,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,835,590.00	3,094,797.03
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,835,590.00	3,094,797.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,950,624.76	31,972,204.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,688,832.26	21,798,310.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,261,792.50	10,173,894.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	105,595,400.57	(2,355,642.65)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	105,595,400.57	(2,355,642.65)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		112,860,098.64
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,860,098.64	110,504,455.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,504,935.78	395,662,772.65	(154,399,919.57)	700,767,788.86
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,504,935.78	395,662,772.65	(154,399,919.57)	700,767,788.86
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	459,504,935.78	395,662,772.65	-64,481,095.67	790,686,612.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	459,504,935.78	395,662,772.65	(154,399,919.57)	700,767,788.86
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	38,411,152.91	38,411,152.91
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,504,935.78	395,662,772.65	(26,069,942.76)	829,097,765.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,729,409,300.00	1,618,904,042.65	110,505,257.35	93.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,729,409,300.00	1,618,904,042.65	110,505,257.35	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,729,409,300.00	1,618,904,042.65	110,505,257.35	93.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,151,874,600.00	1,060,466,515.66	91,408,084.34	92.1
210101	Үндсэн цалин	784,790,500.00	717,355,645.11	67,434,854.89	91.4
210102	Нэмэгдэл	337,437,000.00	307,662,298.95	29,774,701.05	91.2
210104	Урамшуулал	29,647,100.00	35,448,571.60	(5,801,471.60)	119.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,890,900.00	130,638,605.96	6,252,294.04	95.4
210201	Тэтгэврийн даатгал	93,087,500.00	89,840,007.21	3,247,492.79	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	10,949,500.00	10,462,622.12	486,877.88	95.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,475,600.00	5,291,500.00	184,100.00	96.6
210204	Ажилгүйдлийн даатгал	5,475,600.00	5,087,034.56	388,565.44	92.9
210205	Эрүүл мэндийн даатгал	21,902,700.00	19,957,442.07	1,945,257.93	91.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,409,700.00	244,408,800.00	900.0	100.6
210301	Гэрэл, цахилгаан	6,999,900.00	6,999,900.00	-	100.0
210302	Түлш, халаалт	219,709,800.00	219,708,900.00	900.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	17,700,000.00	17,700,000.00	0.0	100.0
2105	Нормативт зардал	136,816,200.00	129,323,120.00	7,493,080.00	94.5
210502	Хоол, хүнс	136,816,200.00	129,323,120.00	7,493,080.00	94.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00	19,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	19,000,000.00	19,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,305,700.00	3,094,797.03	210,902.97	93.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,305,700.00	3,094,797.03	210,902.97	93.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,112,200.00	31,972,204.00	5,139,996.00	86.2

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,938,300.00	21,798,310.00	5,139,990.00	80.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,173,900.00	10,173,894.00	6.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,729,409,300.00	1,616,548,400.00	112,860,900.00	93.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,465,909,600.00	1,353,049,600.00	112,860,000.00	92.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,353,049,600.00	1,353,049,600.00		100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	112,860,000.00	-	112,860,000.00	0.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	263,409,700.00	263,408,800.00	900.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	263,409,700.00	263,408,800.00	900.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	90,000.00	90,000.00	0.00	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	90,000.00	0.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		112,860,098.64		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		110,504,455.99		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэг нь “Хүүхдийн болон багшийн бүх талын тасралтгүй хөгжлийг хангахад хамтран ажиллахад оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл, аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан тасралтгүй хөгжих олон хувилбарт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж менежментийг сайжруулах
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх үр ашигтай зарцуулахад идэвх санаачилгатай оролцох

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,839.3 мянган төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	112,860.1	110,504.5	(2,355.6)
Бараа материал	85,437.7	102,780.9	17,343.2
Үндсэн хөрөнгө	592,388.8	618,240.5	25,851.7
Нийт хөрөнгө	790,686.6	831,525.9	40,839.3
Өр төлбөр		2,428.2	2,428.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	790,686.6	829,097.7	38,411.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	790,686.6	831,525.9	40,839.3

Дээрх санхүү байдлын тайлангийн үзүүлэлтээс харахад дараах дансанд өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 110,504.5 мянган төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9 -д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 102,780.9 мянган төгрөг болж 17,343.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 15,259.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, 16,932.0 мянган төгрөгийн барилгын засварын материал худалдаж авсан нь голлон нөлөөлсөн,
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 618,240.5 мянган төгрөг болж, 25,851.7 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн цэцэрлэгийн 65,481.8 мянган төгрөгийн дээврийн засварын ажлыг капиталжуулж үндсэн хөрөнгөөр бүртгэсэн, тайлант онд 39,630.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,249,025.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 263,409.7 мянган төгрөг, нийт 1,512,434.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 95,529.2 мянган төгрөгөөр бууруулж, 1,416,905.6 мянган төгрөгөөр баталснаас тайлант онд төсөвт нийт 7 удаа зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,465,909.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 263,409.7 мянган төгрөг, өөрийн орлогоос 90.0 мянган төгрөг зэрэг нийт 1,729,409.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу улсын төсвөөс 1,353,049.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 263,408.8 мянган төгрөг, өөрийн орлогоос 90.0 мянган төгрөг зэрэг нийт 1,616,548.4 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,618,904.0 мянган төгрөг буюу 93.6 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 93,253.3 мянган төгрөг, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардлыг 7,272.4 мянган төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 7,493.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
	Улсын төсвөөс санхүүжих				
1	80233-Хүүхэд хамгаалал	1,403.7	1,285.0	118.7	91.5
2	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,517.5	2,310.0	205.5	91.8
3	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	136,816.2	129,323.1	7,493.1	94.5
4	81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	4,368.6	4,250.0	118.6	97.3
5	81823-Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	3,341.8	1,300.0	2,041.8	38.9
6	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,292,790.0	1,199,537.7	93,253.3	92.8
7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	24,671.8	17,399.4	7,272.4	70.5
8	83603-Нэмэлт -Дээд шатны төсвөөс хуваарилсан	90.0	90.0	0.0	100.0
	Дүн	1,465,999.6	1,355,495.2	110,504.4	92.5
	Орон нутгийн төсвөөс				

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

9	8011-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	263,409.7	263,408.8	0.9	100.0
	Дүн	263,409.7	263,408.8	0.9	100.0
	Нийт дүн	1,729,409.3	1,618,904.0	110,505.3	93.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд хүүхдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 1 удаа зарласан боловч оролцогч ирээгүй тул Галил этоос ХХК, Царам мөрөн ХХК, Байгаль транс ХХК, Өгөөж ундрам дэлгэрэх ХХК, Туж ананд ХХК, иргэн Д.Мөнхцэцэг, С.Майнбаяр, С.Батаа нартай тус тус шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари файнэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,318,848.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,782.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй уялдуулан албан хэрэг эрхлэх ажлыг цахимаар гүйцэтгэж байгаатай холбогдон бичиг хэргийн зардлыг хэмнэсэн, хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт оруулаагүй байна. Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл /бүтэн жилээр/-ийг хоцроосон,
- Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг гүйлгээ тус бүрээр тухай бүр оруулаагүй;
- Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрд шийдвэрийн хуулбарыг тухай бүр хавсралт файлаар оруулаагүй;

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.4.5, 6.10 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад биелэлт 83.3 хувьтай байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,489.8	1	1,489.8	100.0
Албан шаардлага	1		1		100.0
Зөвлөмж	2		1		50.0
Нийт дүн	4	1,489.8	3	1,489.8	83.3

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **15,224.6** мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч 220.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 15,003.9 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, улс, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр багш Б.Амгаланд 25 хувиар тооцон **220.7** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн **15,003.9** мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон	1	220.7	1	220.7								
Эцэг эхчүүдээс авсан хичээлийн болон ариун цэврийн хэрэглэгдэхүүнийг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	15,003.9					1	15,003.9				
Дүн	2	15,224.6	1	220.7			1	15,003.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 4 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.	1				1			
Дүн	1				1			



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 142 / А1850 385

Сүхбаатар

107-2025 / 124/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс шилэн дансанд тухай бүр мэдээлбэл зохих дараах 1 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт оруулаагүй зөрчил илэрлээ. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Дараа жилийн төсвийн төсөл 1 удаа,

Огт оруулаагүй

- Цалцнгийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг гүйлгээ тус бүрээр тухай бүр оруулаагүй;
- Цалцнгийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрд шийдвэрийн хуулбарыг тухай бүр хавсралт файлаар гэх мэт.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.4.5, 6.1.10 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: " 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Хонгорзул, нягтлан бодогч С.Алтанцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432504427



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 62/11850 385

Сүхбаатар

100А-2025/124/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, улс, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр багш Б.Амгаланд 25 хувиар тооцон ур чадварын нэмэгдэлд 220.7 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь "Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. "цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь", "сумын түвшинд 15 хувь" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3: "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Үндэслэлгүйгээр олгосон 220.7 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Хонгорзул, нягтлан бодогч С.Алтанцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432505188